

Оюу толгойн уурхайн ус ашиглалтын талаарх түгээмэл асуулт, хариулт

1	“Оюу толгой” компани уурхайн усны хэрэглээгээ малчдын эх үүсвэрээс хангадаг уу?	Үгүй. “Оюу толгой” компани уурхайн усны хэрэгцээгээ малчдын ашигладаг эх үүсвэрээс бус, уурхайн цогцолбороос 35-80 километрын зайд орших Гүний хоолойн газрын доорх усны ордоос авдаг. Энэхүү орд нь газрын гадаргаас 150-400 метрийн гүнд байрлах даралтат гадаргатай уст давхаргаас бүрддэг бөгөөд малчид, таван хошуу мал, зэрлэг амьтдын хэрэглэдэг бага гүний уст үеийн худаг, булаг шандын эх үүсвэрээс тусгаарлагдсан тогтоцтой юм. <i>“Гүний хоолой” газрын доорх усны орд орчмын Булан, Шар дов зэрэг малчдын худгийн усны түвшин сүүлийн арав гаруй жил тогтвортой байгааг доорх графикаас харж болно.</i> График дүрсэлж буй Оюу толгойн усны түвшин, хур тунадас, булаг, шар довны түвшинг 2011-2025 оны туршид. Түвшинг м (ГГД) хур тунадас, мм-ээр дүрсэлж байна.
2	Оюу толгойн ус ашиглалт дэлхийн ижил түвшний уурхайнуудтай харьцуулбал ямар түвшинд байна вэ?	Оюу толгой ус дахин ашиглалтын түвшинг арав гаруй жил тогтмол 80%-аас дээш түвшинд барьж, энэ үзүүлэлтээр дэлхийн уул уурхайн салбарын шилдгүүдийн эгнээнд багтаж байна. 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар баяжуулах үйлдвэр, хөргөлтийн системийн ус, ахуйн хаягдал ус болон шүүрлийн усыг дахин боловсруулж, ашигласнаар ус дахин ашиглалтын түвшин 86.7% байна. - Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулах ус 0.44 м³ байгаа нь дэлхийн дунджаас даруй гурав дахин бага үзүүлэлт юм.

3	Гүний хоолойн усыг олон жил ашиглахад малчдын төдийгүй мал аж ахуйн усан хангамжид нөлөө гарах уу?	Гүний хоолойн уст давхаргыг хариуцлагатай ашиглах нь малчдын усны эх үүсвэрт эрсдэлгүй болохыг хяналт шинжилгээний үр дүнгээс харж болно. Гидрогеологийн нарийвчилсан судалгаа, тэр дундаа “Олон улсын гидрогеологийн холбоо”-ы албан ёсны, шинжлэх ухааны сэтгүүлд нийтлэгдсэн судалгаагаар Гүний хоолойн ус болон малчдын гүехэн худгууд хоорондоо холбоогүй нь батлагдсан. Түүнчлэн уст давхаргын эрдэсжилт нь Монгол Улсын ундны усны стандартад заасан хэмжээнээс 2.5-3 дахин өндөр тул унданд тохиромжгүй. Тиймээс газрын доорх усыг ашиглах нь малчдын худаг, булаг шандын ундны усанд нөлөөлөхгүй.
4	Гүний хоолойн уст давхаргаас хэр хэмжээний ус татдаг вэ? Хоногт хэр хэмжээний ус ашигладаг вэ?	Сүүлийн таван жилийн дунджаас үзэхэд уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй түүхий усны бодит хэрэглээ ус ашиглах зөвшөөрөгдсөн хэмжээний 56.5%-тэй тэнцэж байгаа буюу дунджаар секундэд 518.52 литр/ секунд (2025 оны 11 дүгээр сарын байдлаар) юм. Оюу толгойн уурхай 2011 оноос хойш Монгол Улсын Засгийн газрын зөвшөөрлийн дагуу Гүний хоолойн уст давхаргаас ус татан, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Монгол Улсын Усны нөөцийн зөвлөлөөс 2015 онд 918 литр/секунд буюу хоногт 79,315 м³ ус ашиглах зөвшөөрөл олгосон. Уурхай руу ус татах системд 28 худаг, шахуургын станц, дамжуулах хоолой багтдаг бөгөөд үр ашигтай, алдагдалгүй ашиглах үүднээс нарийн хяналт тавин ажилладаг. Иймд Оюу толгойн уурхайн үйл ажиллагаа уст давхаргын нөөцийг тогтворгүй хэмжээнд хүргэхгүй болохыг харуулж байна.
5	Уурхайн усны хэрэглээнд хэн хяналт тавьдаг вэ?	“Оюу толгой” компани Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнийхөө хүрээнд дотоод хяналт тавьж, усны хэрэглээ, үр ашиг, орон нутгийн усны эх үүсвэрт үзүүлэх нөлөөлөл зэргийг ил тод тайлагнадаг. Тайлан Мөн хэд хэдэн оролцогч тал бүхий байгууллага тогтмол давтамжтай хяналт тавьдаг. Үүнд: Засгийн газрын агентлагууд: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Орон нутгийн Байгаль орчны газар, Сав газрын захиргаа зэрэг байгууллагууд Оюу толгойн уурхайн усны хэрэглээнд хяналт тавьж, зохицуулалтаар хангаж, усны хууль тогтоомж, байгаль орчны дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг нягталдаг. Хөндлөнгийн аудиторууд, зээлдүүлэгчид: Оюу толгойн уурхайд Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) зэрэг олон улсын санхүүгийн байгууллагууд хэсэгчилсэн санхүүжилт олгосон тул олон улсын байгаль орчны стандартад нийцүүлэн ажиллаж, хөндлөнгийн аудитад хамрагддаг. 2024 оны 9 дүгээр сард хийсэн аудитаар ОУСК болон ЕСБХБ-ны стандартын шаардлагыг зөрчсөн зүйл илрээгүй байна. Хамтын оролцоотой хяналт, шинжилгээний хөтөлбөр:

		2011 оноос хэрэгжүүлж эхэлсэн уг хөтөлбөрийн хүрээнд малчдын гар худгийн усны түвшинг тогтмол хянаж байна. Уг хөтөлбөрийг 2018 оноос орон нутгийн иргэдийн санаачилгаар байгуулагдсан, сайн дураар үйл ажиллагаагаа явуулдаг “Мөнх Ногоон Галба” ТББ Оюу толгойн санхүүгийн дэмжлэгтэйгээр хариуцаж байна. Оюу толгой 69 энгийн гар худагт усны түвшний хэмжилт хийдэг бол “Мөнх Ногоон Галба” ТББ орон нутгийн хамтын оролцоотой хөтөлбөрийн хүрээнд 87 худагт хэмжилт хийдэг. Эдгээрээс 15 худгийг хоёр байгууллага хамтран хянадаг бөгөөд хэмжилтийн зөрүү маш бага буюу 0.05–0.20 метрийн хооронд байна. Үүнд: • Ханбогд сумын малчдын энгийн гар худаг, гүний өрөмдлөгийн худаг, ирээдүйд ашиглах худаг, гүний хоолойн уст давхаргын хяналт шинжилгээний худгуудад усны түвшин хэмжилт хийх; • Нуур, цөөрмийн хяналт шинжилгээ хийх; • Ундны усны чанарын үнэлгээ хийх. Энэхүү хяналт шинжилгээний үр дүнгээ 2024 онд төрийн байгууллага, эрдэмтэн судлаачид, орон нутгийн төлөөллийг нэг дор цуглуулж “Ханбогдын усны чуулган”-д танилцуулсан нь талууд ус хамгааллын чиглэлээр мэдлэгээ хуваалцаж, солилцох арга хэмжээ болсон. Үндэсний хөндлөнгийн усны аудит Мөн Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд заасан аудитын хүрээнд таван жил тутамд Хөндлөнгийн байгууллага усны ашиглалтын аудит хийдэг. Хөндлөнгийн байгууллага 2016, 2021 онд хийсэн аудитын тайланг Оюу толгойн цахим хуудсанд нээлттэй байршуулсан байдаг.
6	Оюу толгой бүсийн нутгийн түвшинд орон нутгийн усны аюулгүй байдлыг сайжруулахын тулд ямар төсөл санаачилга хэрэгжүүлж байна вэ?	“Оюу толгой” компани Өмнийн говийн бүс нутагт усыг ууршихаас хамгаалж, газар дор хуримтлуулах далан барьж туршихаар төлөвлөж байна. Энэхүү “Газрын доорх усыг арвижуулах туршилтын” төслийн хээрийн судалгаа 2025 онд дууссан бөгөөд барилгын ажлыг 2026 оны 2 дугаар улиралд эхлүүлэхээр төлөвлөсөн. Мөн орон нутгийн бэлчээр усжуулалтын хүртээмжийг сайжруулах хүрээнд 2011 оноос 161 гар худгийг сэргээн засварласан. Гүн өрөмдлөгийн 19 худаг, технологийн зориулалттай 30 худагт нийт 50 ширхэг нарны толь суурилуулж, 12 худгийн байшинг шинээр барьж, засварлан сайжруулснаар нийт 1.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. Тухайлбал: - 13,000 хүнийг цэвэр усаар хангах хүчин чадалтай Ханбогд сумын төвийн ус хангамжийн цогцолборыг 2017 онд барьж байгуулахад 6,9 сая ам.доллар зарцуулав. Газрын доорх усыг арвижуулах туршилтын төсөлд 15 мянган ам.доллар;
7	“Оюу толгой” компани усны нөөц ашигласны төлбөрт	2022 оны 11 дүгээр сар хүртэл Монгол Улсын Засгийн газрын 326 дугаар тогтоолын дагуу 1 шоо метр ус ашигласны төлбөрт Оюу толгой 959.04 төгрөг төлдөг байсан. 2022 оны 11 дүгээр сард Монгол Улсын Засгийн газрын 416 дугаар тогтоолоор тарифыг 75 хувиар нэмэгдүүлж, 959.04 төгрөг байсныг 1678.32 төгрөг болгосон. “Оюу толгой” компани 2023 оны нэгдүгээр сараас ус ашигласны төлбөрөө

	ямар тариф хэрэгжүүлдэг вэ? Нийт хэдэн төгрөг төлдөг вэ?	энэхүү нэмэгдүүлсэн тарифаар буюу 1 шоо метр ус ашигласны төлбөрт 1678.32 төлж байна. Энэхүү тариф нь зөвхөн газрын доорх усны нөөцийг ашигласан төлбөр юм. Харин ус олборлох болон ус зөөвөрлөх бусад дэд бүтцийн зардлыг Оюу толгой хариуцдаг.
8	“Оюу толгой” компани ус ашигласны төлбөрт жилд хэдэн төгрөг төлдөг вэ? Хэдэн хувь нь улсын төсөвт, хэдэн хувь нь аймаг/сумын төсөвт ордог вэ?	2016 онд “Оюу толгой” компани болон Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны хооронд байгуулсан Ус ашиглах гэрээний 1.8.2 дугаар зүйлд заасны дагуу үйлдвэрийн зориулалтаар ус ашигласны төлбөрийг Өмнөговь аймгийн төсөвт, харин унд, ахуй, угаалгын зориулалтаар ашигласан усны төлбөрийг Ханбогд сумын төсөвт төвлөрүүлдэг. Ус ашиглах гэрээнд заасанчлан жил бүрийн ус ашиглах төлөвлөгөөнд үндэслэн ашигласан усны хэмжээг зориулалт тус бүрээр тооцож, ус ашиглалтын дүгнэлт гаргуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар” байгуулагдсантай холбоотой 2025 оны “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг гаргуулах хүсэлтийг цахим системээр хүргүүлж 2025 оны 5 сарын 14-ний өдөр батлуулан авч уг дүгнэлтийн дагуу ус ашиглаж байна. “Оюу толгой” компани 2013 оноос хойш 2025 оны байдлаар ус ашигласны төлбөрт нийт 218 тэрбум төгрөг төлөөд байна.
9	“Оюу толгой” компани ус дахин ашиглалт 86.7%-тай гэж хэлж байна. Үүнийг хэрхэн баталгаажуулдаг вэ?	“Оюу толгой” компани ус ашиглах тухай хууль, тогтоомжид заасны дагуу төрөл бүрийн дотоод болон гаднын аудит, үзлэг, шалгалтад хамрагддаг. Аудитын байгууллага гэдэгт дараах байгууллагууд багтана: • Зээлдүүлэгчдийн БОНХЗ-ийн аудит: БОННУ-нд нийцэж байгаа эсэхийг шалгах зорилгоор жилд 2-3 удаа хийж, үр дүнг олон нийтэд мэдээлдэг. • Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийн хөндлөнгийн аудит: Байгаль орчны шаардлага, үндэсний стандартад нийцэж байгаа эсэхийг шалгах зорилгоор 2 жил тутамд хийж, олон нийтэд мэдээлдэг. • Байгаль орчны гүйцэтгэлийн аудит жил бүр: БОНБНУ-ний дагуу жил тутмын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг шалгана - Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл - Олон нийтэд мэдээлдэг. • Усны хөндлөнгийн аудит : Устай холбоотой бүх дүрэм, журам, мөн Хөрөнгө оруулалтын гэрээний устай холбоотой заалтуудын биелэлтийг шалгах зорилгоор 5 жил тутамд хийж, олон нийтэд мэдээлдэг. • Үндэсний аудитын газар: Монгол Улсын Их Хуралд танилцуулсан. • Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны усны аудит: Жилд нэг удаа ерөнхийд нь.

- Copper Mark байгууллагын аудит: Хоёр жил тутамд хийдэг Зээлдүүлэгчдийн аудиттай хамтатган явуулдаг.
- Монгол Улсын Засгийн газраас томилогдсон ажлын хэсгийн шалгалт.



10	Оюу толгой усыг юунд ашигладаг вэ?	Усыг баяжуулах үйлдвэр, дулааны станцын зуухны системийн хөргөлт, тоос дарах, усалгаа, зам барилга, замын болон барилгын материалын үйлдвэрлэл зэрэг олон зориулалтаар дахин ашигладаг.
11	Хэрлэн-Тооно төслийн талаар “Оюу толгой” компани ямар байр суурьтай байна вэ?	Хэрлэн- Тооно төсөл нь Оюу толгойн газрын доорхи ус ашиглалттай холбоогүй, Монгол орны хойд хэсгээс гадаргын усыг татаж, говийн бүс нутагт хүргэх зорилготой. 2024 оны 5 дугаар сард “Оюу толгой” болон “Эрдэнэс Оюу Толгой” компаниуд “Хэрлэн-Тооно” төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх шинэ гэрээнд гарын үсэг зурсан. Монгол Улсын 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан энэхүү чухал санаачилгыг хэрэгжүүлэхэд “Оюу толгой” компани дэмжлэг үзүүлж байна.
12		

